



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 4/180

Хархорин сум

Аян зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.7, 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагын албан хаагчдыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Гэмт хэрэг, зөрчилгүй хамт олон" аяныг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд зохион байгуулсугай.

2.Аяны хүрээнд "Гэмт хэрэг, зөрчилгүй хамт олон" уриалга бүхий аяны тугийг дэвтрийн хамт байгууллагуудаар аялуулахыг Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн (Н.Нямдаваа)-д, тугийг хүлээн авсан байгууллагууд аяны хүрээнд байгууллага дээрээ гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах талаар тодорхой ажил зохион байгуулж ажиллахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус даалгасугай.

3.Аяны хүрээнд шинэ санаа, санаачилга гаргаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй оролцсон байгууллагыг шалгаруулж, урамшуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Лхагвадулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100319